



2024.06.07 Хугацаа 60 минут А хувилбар Хэрлэн сум  
Нийт оноо: 40 Анги: Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Эрвээхэй**

Өнгө өнгийн гоёмсог далавчтай эрвээхэйн араас хөөцөлдөх зуны улирал хаяанд иржээ. Үзэсгэлэнтэй цэцэгсийн дэлбээнд дурлан тоос хүртэх тэдгээр бяцхан амьтад тавдугаар сарын сүүлч, зургадугаар сарын эхээр үзэгдэж эхэлдэг. Дэлхийд нийт 100 мянган төрлийн эрвээхэй бий. Тэдгээрээс ихэнх нь манай оронд байдаг аж. Монгол оронд 1000 орчим зүйлийн эрвээхэй бий хэмээн бүртгэсэн байдаг боловч өнөөг хүртэл дагнасан судалгаанууд хийгдээгүй байна.

Эрвээхэй олон янзын гоёмсог хээ бүхий хос далавчтай хээнцэр ганган шавж ажээ. Далавч нь хайрсаар хучигдсан байдаг учраас хайрсан далавчтаны багт хамаарна. Гэвч огт далавчгүй ч төрөл зүйл бий. Эрвээхэй нь урт нарийн хоолой маягийн өвөрмөц эрүүтэй, тэр нь хуйлж цагирагласан хэлбэртэй. Энэ төрх нь бусад шавжнаас онцгой ялгарна. Биеийн хэмжээ болон далавчны хэмжээ харилцан адилгүй.

Монгол орны хамгийн том эрвээхэй нь папилион буюу тогосын нүдэн эрвээхэй овог бол ойт хээрийн бүсээр хамгийн түгээмэл тархацтай нь одот цагаан эрвээхэй юм. Том биерхүү, хос далавч нь гоёмсог нүдэн толботой. Далавч нь дэлгэмэл байдлаараа 50-75 миллиметр хүрдэг. Тогосон нүдэлт, бүгэг зэрэг төрлийн эрвээхэйнүүдийн далавчны дэлгэц 30 гаруй сантиметрт хүрдэг байхад хивэн эрвээхэйнийг гуравхан миллиметр байдаг байна. Одот эрвээхэй далавчaa дэлгэсэн үед хамгийн хээнцэр гоё бөгөөд далавчны дэлгэц 7-9 сантиметр болно. Эрвээхэйн авгалдайн хөгжил нь түүний амьдралын ихэнх хэсэг бөгөөд далавч ургаж ниссэнээс хойш 24-хөн цаг болоод амьдралынх нь хугацаа дуусаж үхдэг эрвээхэйн төрлүүд олон байдаг байна.

Манай оронд хамгийн ихээр тархсан төрөл бол хүр эрвээхэй юм. Түүнийг том цагаан далавчаар нь ялгаж болно. Энэ эрвээхэй нь намрын улиралд авгалдайгаа шахах гэрэлтэй, дулаан газар хайн нүүдэллэдэг. Үүний тулд 150 км-ийн цаанаас нисэж ирэх нь бий. Хүр эрвээхэй нь хар модонд авгалдайгаа шахдаг. Намар гарсан авгалдай нь хавар бүрхүүлээсээ гардаг. Хүрэнцэр нь хаврын турш modoор хооллож, модыг ихээр нь сүйтгэдэг аюултай. Гэхдээ хавраас намар хүртэл хооллоод бусад үед хооллодогтгүй. Хүрэнцэр долдуугаар сараас хүүхэлдэй шатандаа орж улмаар наймдугаар сард эрвээхэй болдог. Энэ үед эрвээхэй нь эвцэлдэж, авгалдайгаа шахах тохиromжтой газрыг хайн нүүдэллэдэг. Харин авгалдайгаа шахсан эрвээхэй шууд үхдэг ажээ.

([http://www.touristinfocenter.mn/cate10\\_more.aspx?ItemID=69](http://www.touristinfocenter.mn/cate10_more.aspx?ItemID=69), Монголд улаан номд орсон ганцхан эрвээхэй бий (paparazzi.mn)

1. Эхээс нэг баримтыг сонгож бичээд, баримтын ямар төрөл болохыг тодорхойлоорай. /2 оноо/

№	Баримт	Төрөл
1		

2. "Хүрэнцэр нь хаврын турш modoор хооллодог. Хүрэнцэр нь модыг ихээр нь сүйтгэдэг аюултай." гэсэн энгийн өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгож, холбогдсон аргыг тайлбарлаарай. /2оноо/

Холбогдсон арга:

3. Дараах өгүүлбэрээс найрах аргаар холбогдсон угсарсан нийлмэл үг 2-ыг олж бичээрэй.  
/2оноо/

Өнгө өнгийн гоёмсог далавчтай эрээхэйн араас хөөцөлдөх зуны улирал хаяанд иржээ.

4. Онцолсон бүтээврийг шалтгааны утгат үг /бүтээвэр/-ээр солин найруулж бичээрэй.  
/2 оноо/

Далавч нь хайрсаар хучигдсан байдал учраас хайрсан далаачтаны багт хамаарна.  
Солин найруулсан нь:

5. Үгэнд нөхцөлийг залган бичээд, зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу. /2оноо/  
урь+сан= .....

Дүрэм: .....

6. Уран зохиолын хичээлээр уншсан зохиолоосоо сонгоод өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ  
60-70 үгэнд багтаан бичээрэй. /Боноо/


7.Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. /Боноо/

БАЙГААЛ  
Д.БАЙГАЛМАА  
БАЙГААЛ  
Д.БАЙГАЛМАА

БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР *Д.БАЙГАЛМАА*

Материал зассан: Бааш





2024.06.07

Хугацаа 60 минут

В хувилбар

Хэрлэн сум

Нийт оноо: 20

Анги:

Сурагчийн нэр:

Эхийг анхааралтай уншаад даалгаврыг гүйцэтгээрэй.

**Тоншуул**

Тоншуул нь Picidae овог бөгөөд Австрали, Шинэ Зеланд, Мадагаскар, туйлын бүсээс гадна дэлхийн бусад бүх хэсэгт өргөн тархсан шувуу юм. Нийт 30 төрөл, 200 зүйл тоншуул бий. Эдгээр шувууд нь ой хөвч, модот газар амьдрах ба мөн цөөн хэдэн зүйл нь хадархаг уул, цөлд нутаглах аж. Өдгөө нэлээд зүйлийн тоншуул нь байгаль орчны өөрчлөлт, тархуу амьдрах зэргээс шалтгаалан ховордож цөөрөөд байна.

Толгой дээр нь улаан толботой титэмтэй өднийх нь ногоон өнгө нь том хэмжээтэй байхаас гадна түүнийг үл анзаарах болно. Тоншуул бол харьцангуй том шувуу бөгөөд далавчаа дэлгэхэд 40 см хүрдэг. Түүний өд нь маш үзэмжтэй, голчлон ногоон өнгөтэй, хэвлэй хэсэг нь бага зэрэг шаргал, сааралдуу, ууц шаргал өнгөтэй, толгой дээр нь гурван улаан толботой, нэг нь титэм эсвэл титэм дээр, нөгөө хоёр нь хацрын хэсэгт сахал гэж нэрлэгдэг бөгөөд насанд хүрсэн хүн эмэгтэй байх үед хар өнгөтэй болдог. Нүдний эргэн тойрон дахь өд нь хар өнгөтэй байдаг. Залуу наасны өд нь маш алагтай. Модны гадаргууг атгах зориулалттай хүчтэй хөлтэй. Хэл нь шавжийг нүхнээс гаргах зориулалттай тул толгойноосоо маш урт юм.

Тоншуул бол ойн шувуу бөгөөд голын эргийн ой нь түүний хамгийн дуртай экосистем юм. Тэд мөн бутлаг газар, тэр ч байтугай цөөхөн модтой нугад амьдарч болно. Тэд далайн түвшнээс 1200 метрийн өндөрт амьдрах боломжтой бөгөөд тэнд суурьшдаггүй. Энэ шувууны амьдрах орчин нь хоол хүнс, орон байраар тодорхойлогддог. Хошуугаараа өрөмдөхөд хялбар улиас зэрэг зеөлөн модыг илүүд үздэг.

Эдгээр шувуудын үржлийн улирал ойролцоогоор 3-р сарын сүүлээр ирдэг. Эцэг эх хоёулаа үүр барихаас эхэлдэг бөгөөд маш зеөлөн эсвэл ялзарсан дунзэнд 40 см гүн үүрээ бүтээхэд нэг сар хүртэл хугацаа шаардагдана. Эм тоншуул үүрээ барьсны дараа 6 орчим өндөг өндөглөдөг бөгөөд хоёр долоо хоног гаруйн дараа өндөг гарч, эцэг эх хоёулаа дэгдээхэйгээ тэжээх ба энэ нь ердөө сар хүрэхгүй хугацаа юм.

[\(Тоншуул - Wikiwand, \(1\) New Message! \(fascinatesanimals.com\)\)](#)

2. Эхээс нэг баримтыг сонгож бичээд, баримтын ямар төрөл болохыг тодорхойлоорой. /2 оноо/

№	Баримт	Төрөл
1		

2. "Тоншуул нь маш хүчтэй хөлтэй. Түүний хөл нь модны гадаргууг атгах зориулалттай байдаг." гэсэн энгийн өгүүлбэрийг шалтгааны утгатай нийлмэл өгүүлбэр болгож, холбогдсон аргыг тайлбарлаарай. /2оноо/

Холбогдсон арга:

3. Дараах өгүүлбэрээс найрах аргаар холбогдсон угсарсан нийлмэл үг 2-ыг олж бичээрэй.  
/2оноо/

Хошуугаараа өрөмдөхөд хялбар улиас зэрэг зөвлөн модыг илүүд үздэг.

4. Онцолсон бүтээврийг шалтгааны утгат үг /бүтээвэр/-ээр солин найруулж бичээрэй.  
/2 оноо/

**Хэл нь шавжийг нүхнээс гаргах зориулалттай тул толгойноосоо маш урт юм.**


Солин найруулсан нь:

5. Үгэнд нөхцөлийг залган бичээд, зөв бичгийн дүрмийг тайлбарлана уу. /2оноо/  
тавь+даг= .....

Дүрэм: .....

6. Уран зохиолын хичээлээр уншсан зохиолоосоо сонгоод өөрт төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ 60-70 үгэнд багтаан бичээрэй. /Боноо/

7.Үндэсний бичгээс кирилл бичигт хөрвүүлээрэй. /Боноо/



БОЛОВСРУУЛСАН: СУРГАЛТЫН МЕНЕЖЕР  
  
Д.БАЙГАЛМАА  
Материал зассан: Багш